


ЦАХИЛГААН ХАЛААГУУР (Ceramic fan heater)

AC200-240V 50/60Hz 1400/2000W



АШИГЛАЛТЫН ЗААВАР

AE-H6

Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө ашиглалтын заавартай сайтар танилцана уу



1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

1. Бүтээгдэхүүний цахилгааны утсыг залгуурт залгаж, арын асаагуурыг дарснаар төхөөрөмжийн дэлгэцэнд орчны агаарын хэмийг харуулж, үйл ажиллагааны бэлэн байдалд шилжинэ.

2. ON/OFF товчлуур: Эхний удаад "  " товч дарснаар төхөөрөмж ажиллаж эхлэх ба агаарын урсгал үүсгэх сэнсний гэрэл асна. Ахин "  " дарахад унтарна.

3. Халаалтыг шууд удирдах: "ON/OFF" товч дарсны дараа "  " товч дарахад "  " гэрэл асч, халаалтын бага горимд /1400W/ ажиллана.

"  " товчийг ахин дарахад "   " гэрэл асч, халаалтын их горимд /2000W/ ажиллана. Гурав дахь удаа "  " товчлуур дарахад халаалтын горим унтарна.

4. Температураар удирдах: "  " товч дарахад , агаарын температур 25

хэмийг шууд заана. Ахин дарж 25-40 хэмийн хооронд **зорилтот** агаарын температураа өөрчилж болно. Температураар халаалтын горимыг удирдах

ажиллагааг зогсоохын тулд "  " товч дарахад халаах функц зогсч, зөвхөн сэнс ажиллана. Хэрэв таны **зорилтот** агаарын хэм бодит орчны

хэмээс 2°C - 3°C их бол төхөөрөмж халаалтын бага горим дээр "  " ажиллана. Хэрэв таны **зорилтот** агаарын хэм орчны хэмээс 4°C-аас их бол

халаалтын их горим дээр "   " ажиллана. Хэрэв **зорилтот** агаарын хэм орчны хэмээс 1°C их, эсвэл ижил, бага бол халаах функц зогсч зөвхөн агаарын эргэлтийг дэмжих сэнс ажиллана.

5. Цагийн тохиргоо: 12 цаг.

6. Төхөөрөмжийн гэрлийг унтраах, товчны ажиллагааг цоожлохын тулд

  In /температур болон цагийн тохиргоо товч/ 3 секундын турш зэрэг дарна. Цоожлох үйлдлийг арилгахын тулд дээрх 2 товчыг мөн зэрэг 3 секунд дарна. Мөн дэлгэцийн гэрлийг унтраахын тулд эргэх  хөдөлгөөний товчин дээр удаан дарна. Дэлгэцийг идэвхижүүлэхийн тулд дурын товчин дээр дарна.

2. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ:

- Энэхүү төхөөрөмжийг (халаагуур) хэрэглэхийн өмнө хэрэглэгч уг ашиглалтын зааврыг сайтар уншиж ойлгох ёстой.
- Аюулгүй ажиллагааны бүхий л зөвлөмжийг чанд мөрд! Буруу үйлдэл нь таны болон бусдад аюултай хор нөлөөллийг учруулж болно.
- Ашиглалтын зааврыг байнга уншиж, цаашдын хэрэглээнд хадгал.
- Хэрэв төхөөрөмжийг та бусдад дамжуулах эсвэл худалдах бол энэхүү ашиглалтын зааврыг дагалдуулж өгөх ёстой.
- Төхөөрөмжийг түүний бүхий л функц, чиг үүргүүд нь бүгд ажиллаж байгаа нөхцөлд ашиглана. Хэрэв төхөөрөмж, зарим бүрдэл хэсэг нь согогтой, ажиллахгүй бол унтрааж, засварлаж дууссаны дараа ажиллуулна.
- Тэсэрч дэлбэрэх аюултай нөхцөл, шатах шингэн, хий бүхий өрөөнд төхөөрөмжийг хэзээ ч ажилуулж болохгүй.
- Төхөөрөмжийг санамсаргүйгээр ажиллаж эхлэхээс сэргийлж бүрэн унтраасан эсэхийг байнга шалга.
- Хүүхэд болон бие даан төхөөрөмжийг ажиллуулах чадваргүй хэн нэгэн төхөөрөмжийг ажиллуулахыг оролдох, тоглох, ойртохыг хориглоно.
- Төхөөрөмжийг хэт ачааллаж болохгүй. Төхөөрөмж нь хэвийн нөхцөлд ажиллуулахад зориулагдсан болно.

ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ:

- Төхөөрөмжийн цахилгааны ишнүүр нь зөв суурилагдсан залгуурын үүрт (разетка) холбогдоно.
- Төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэнд заасан цахилгааны хүчдэл нь залгуурын үүрийн үзүүлэлттэй нийцсэн байна.
- Төхөөрөмжийн цахилгааны ишнүүр, залгуурын үүртэй нойтон гараар харьцахыг хориглоно.
- Цахилгааны утсыг нугалах, шахах, татахыг хориглох ба хурц эдлэл, тос болон халуунаас хамгаалах шаардлагатай.
- Цахилгааны утсыг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.
- Хэрэв цахилгааны утас гэмтсэн байвал, залгуураас нь шууд салга.
- Төхөөрөмжийг ашиглахгүй бол залгуураас нь салгана.
- Төхөөрөмжийг зөөх, тээвэрлэхээс өмнө залгуураас салгана.

ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ:

- Төхөөрөмжийн хүрээлж буй орчин нь тэсэрч дэлбэрэх, шатах материалаас ангид байх ёстой.
- Төхөөрөмжийг дотоод орчинд буюу зөвхөн өрөөнд, ахуйн зориулалтаар ашиглана.
- Төхөөрөмжийг насанд хүрэгч, харгалзах хүнгүйгээр хэрэглэхийг хориглоно.
- Төхөөрөмжийн агаар сэлгэлт хийх тороор халхлагдсан хэсэг рүү ямарваа гадны биет хийхийг хатуу хориглоно.

- Төхөөрөмжийн агаар сэлгэх хэсэг болон шатамхай материал хооронд багадаа 90 см-ийн зайтай байна.
- Төхөөрөмжинд ус болон бусад шингэн зүйлс асгах, хийхийг хориглоно.
- Төхөөрөмжийг угаалгын өрөө, шүршүүр, усан сан болон ус дамжуулах хоолой холбогдсон өрөөнд ашиглаж болохгүй.
- Төхөөрөмжийг бүтээж болохгүй. Галын аюултай.
- Төхөөрөмжийг цахилгааны залгуурын үүрийн доор байрлуулж болохгүй.
- Төхөөрөмжийг харгалзах хүнгүйгээр хүүхэд ажиллуулахыг хориглоно.
- Уг төхөөрөмж нь ажиллаж байх үедээ аажмаар халдаг. Түлэгдэхээс сэргийлж, халуун гадарга дээр хүрэхээс зайлсхий.
- Төхөөрөмж дээр байх анхааруулах тэмдэг, наалдацыг авахыг хориглоно.



- Энэхүү төхөөрөмжийн зарим хэсэг нь маш халуун болж, түлэгдэх нөхцөл үүсгэж болно. Иймд ойр тойронд байгаа бага насны хүүхэд, өртөмтгий хүмүүст онцгой анхаарал тавь.



- Төхөөрөмжийг бүтээх, дээр нь аливаа зүйл тавихыг хориглоно.